

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БОЛОН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН 2010 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

2011.03.22

Чойбалсан

Аймгийн Засаг даргатай, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга байгуулсан 2010 оны үр дүнгийн гэрээний биелэлтэд 2010 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ. Үр дүнгийн гэрээний хавсралтаар батлагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 116 бүтээгдэхүүн тусгагдсанаас 94.63 хувийн биелэлттэй гарлаа. Бүтээгдэхүүний биелэлтийг салбар бүрээр танилцуулбал:

1.1.Төрийн бодлогын хүрээнд 9 бүтээгдэхүүн тусгагдсанаас 2010 оны жилийн эцсийн байдлаар 95.5 хувьтай хэрэгжсэн бөгөөд 100 хувьтай 7 бүтээгдэхүүн, 90 хувьтай 1 бүтээгдэхүүн, 70 хувьтай 1 бүтээгдэхүүн биелэгдсэн байна.

Төрийн бодлогын хүрээнд “Орон нутагт жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь”, “Төрийн албаны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал”, “Авилга”, “Архидалт”, “Эмгэтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил мөн” “Аялал жуулчлал”, “Аймгийн гадаад харилцааны хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай” гэх мэт олон талт сэдвүүдээр нээлттэй хэлэлцүүлгүүдийг амжилттай зохион байгуулсан бөгөөд Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах, түүнд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлж зорилгоор сар бүрийн 30-ны өдрийг Иргэдтэй уулзах өдөр, мөн жилд нэгээс доошгүй удаа “Нээлттэй хаалганы өдөр”-ийг тус тус зохион байгуулж хэвшээд байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу хяналт-шинжилгээг хийж дүнг удирдлагуудад танилцуулж хэвшээд байна. Мөн Төрийн албан хаагчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газраас сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, хяналт шинжилгээний ажилтан нарыг хамруулсан “Төрийн албан хаагчийн эрх үүрэг, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр сургалт, “Ёс зүйтэй манлайлал” аяны хүрээнд төрийн албан хаагчид, удирдах албан тушаалтныг хүнд суртал, авлигаас хөндий байлгах, төрийн үйчилгээг ил тод болгох чиглэлээр аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагийн дарга нарыг хамруулсан сургалт зэргийг амжилттай зохион байгууллаа.

Орон нутгийн иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний ил тод шуурхай байдал, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор “Шилдэг сум”, багийн хөгжлийг дэмжих дэд

хөтөлбөрийн хүрээнд “Шилдэг баг” шалгаруулах болзол батлуулан “Шилдэг сум” 1-3 байр, “Шилдэг баг” –аар тус бүр 6 баг шалгаруулж, урамшуулан ажиллаа.

Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр аймаг орон нутгийн цаг үеийн байдал, төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийн талаар иргэдэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор орон нутгийн “ТВ6”, “Шинэ суваг”, “Дорнод сонин” зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллахын зэрэгцээ аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар “Олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлах журам” батлуулан ажиллаа.

1.2.Гадаад харилцааны хүрээнд 8 бүтээгдэхүүн тусгагдсанаас 100 хувь биелэгдсэн 7 бүтээгдэхүүн, 90 хувь биелэгдсэн 1 бүтээгдэхүүн хэрэгжиж дунджаар 98.75 хувийн дүнтэй байна.

Аймгийн гадаад харилцааг хөгжүүлэх зорилтын хүрээнд БНХАУ-ын Хөлөнбуйр хоттой хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Цагаан сар угтах баяр”-т оролцохын зэрэгцээ ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Чита хотноо 5 дугаар сард Чойбалсан хотын соёлын өдрүүдийг зохион байгуулж, албан ажлын болон урлаг, спортын, олон арга хэмжээнд амжилттай оролцлоо. Мөн хөрш зэргэлдээ улс болон зүүн бүсийн 3 аймгуудын хэмжээнд “Аялал жуулчлал хөгжүүлэх нөөц, боломж” сэдэвт онол практикийн бага хурал болон урлаг, уран сайхны олон талт арга хэмжээг Дорнод аймагт анх удаа амжилттай зохион байгуулж, 130 гадаад, дотоодын төлөөлөгчдийг хамрууллаа.

БНХАУ-ын Хөнан мужаас зохион байгуулсан “Зүүн хойд Азийн Аялал жуулчлалын хурал, арга хэмжээ”, БНСУ-ын Кенжү хотод зохион байгуулагдсан “Олон улсын эдийн засгийн форум” уулзалт, зүүн хойд Азийн Засаг захиргааны холбооны ээлжит бүгд хуралд зэрэг томоохон арга хэмжээнүүдэд оролцохын зэрэгцээ зүүн хойд Азийн Хүүхэд, эмэгтэйчүүдийн салбар хороог манай аймагт байгуулах боломж бүрдсэн бөгөөд ингэснээр Зүүн хойд Азийн Засаг захиргааны холбооны гишүүн газруудын дунд олон улсын арга хэмжээ зохион байгуулах нөхцөл бүрэлдэж, нийгэм, эдийн засгийн салбарт тодорхой ач холбогдол өгөх юм. Мөн хөрш зэргэлдээ 3 улсын аялал жуулчлалын өдөр арга хэмжээг “Хөрш зэргэлдээ 3 улс болон зүүн бүсийн хэмжээнд аялал жуулчлал хөгжүүлэх нөөц, боломж” сэдэвт онол практикийн бага хурал, Монгол туургатны үндэстний хувцасны загварын наадам, үзэсгэлэн худалдааг амжилттай зохион байгууллаа.

ОХУ-ын Чита хот, Агын буриадын тойрогтой хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулан, БНХАУ-ын Хөлөнбуйр хотын Худалдааны газрын дэд даргатай 2 улсын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах талаар ярилцаж, санамж бичигт гарын үсэг зурлаа. Чойбалсан-БНХАУ-ын Хайлаар хот чиглэлийн агаарын шугам нээгдэж, 3 дугаар сард нээлтийн ёслол болж нислэгийн хуваарийн дагуу тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

ОХУ-ын Чита хот болон Чойбалсан хотын 2010-2013 онд хамтран ажиллах хэлэлцээр, гэрээ байгуулсан гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Мөн Сүмбэр-Рашаантын боомтыг нээн ажиллуулахад бэлтгэл ажлыг хангах хүрээнд Монголын талын хил доторх 50 км намагтай газрыг тэгшлэх, Дэгээ гол дээгүүр гүүр барих, хилийн цэргийн байр барих ажлыг хятадын талын хөрөнгө оруулалтаар хийхээр тохиролцож ажил эхлэл шатандаа байна.

1.3.Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 8 бүтээгдэхүүн тусган хэрэгжилтийг ханган ажилласан байна. Үүнээс 100 хувьтай 7 бүтээгдэхүүн, 90 хувьтай бүтээгдэхүүн 1 байна. Иймд энэхүү хүрээний тусгагдсан бүтээгдэхүүний дүн 98.75 хувьтай байна.

Энэхүү бүтээгдэхүүний хүрээнд хийгдсэн ажлуудаас дурьдвал: Архидан согтуурах явдлын шалтгаан нөхцлийг тогтоох түүнийг арилгах арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2010 оны 216 дугаар захирамжаар “Архидан согтуурахтай тэмцэх аймгийн дэд “ хөтөлбөр батлуулах, Хүүхдийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, насанд хүрээгүй хүүхдийн гэрч, хохирогч нарыг хамгаалалтанд авах, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд туслан дэмжих, тэдэнд нөлөөлж буй сөрөг зүйлийг таслан зогсоох зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 70 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгаалах хороог” 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан ажиллах гэх мэт ажлуудыг амжилттай зохион байгуулан хэрэгжүүлж байна. Аймгийн Засаг даргын 2010 оны 246 дугаар захирамжаар байгуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд авлигатай тэмцэх орон нутгийн сүлжээнээс “Авлигын тухай ойлголт”, Авлигын эсрэг төлөвлөгөө” зэрэг сэдвээр сургалтуудыг 5 удаа 228 иргэд, хөдөлмөрчдийг хамруулан зохион байгуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төрийн үйчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор аймгийн 7 суманд байнгын пост, кабон барьж ашиглалтад оруулаад байна. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Бүсийн радиотой хамтран 7 хоног бүр “Малчдын дуу хоолой” нэвтрүүлэг, “Сураг ажиг” булан ажлуулж, малын хулгай болон алдуул мал, сураг ажиг, мэдээ мэдээллийг утсаар шууд болон мессежээр авах ажлыг зохион байгуулж байна.

2.1. Хүн амын бодлогын хүрээнд нийт 14 бүтээгдэхүүн тусгаснаас 100 хувь биелэгдсэн 10, 90 хувь биелэгдсэн 4 бүтээгдэхүүн байна. Хүн амын бодлогын хүрээнд тусгасан бүтээгдэхүүний биелэлтийн дүн 97.14 хувьтай байна.

Хүн амын бодлогын хүрээнд Эх орны хувь хүртээх үйлчилгээний 70.0 мянган төгрөгийг 100 хувь хүртээд байна. Мөн 30 өрхийн 40 иргэнийг ажилд зуучилж, 60 өрхийн

62 иргэнийг нийтийг хамарсан ажилд, 42 өрхийн 49 иргэнийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад, 26 өрхийн 66 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд, 15 өрхийн 41 иргэнийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд, Засаг даргын Тамгын газрын нөөцөөс 33 өрхийн 123 иргэнд тусламж, 3 өрхөд гэр, 16 өрхийн 18 иргэнийг бичиг баримтжуулж, 29 өрхийн 46 иргэнд ногооны үрийн дэмжлэг, 78 өрхийн 268 иргэнд хувцас болон мөнгөн тусламж, 40 өрхийн 44 иргэнийг боловсролыг дэмжих үйлчилгээнд, 25 өрхийн 62 иргэнийг эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнд, 34 өрхийн 72 иргэнийг бусад төсөл хөтөлбөрт хамруулж, нийт 258 өрхийн амьдралд бодит өөрчлөлт гараад байна.

Мөн нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 4831.1 сая төгрөг оруулахаас 5313.5 сая төгрөгийг төвлөрүүлэн, төлөвлөгөөг 100.9-110.0 хувиар сар бүр жигд ханган биелүүлсэн дүнтэй байна.

Монгол үндэстний уламжлалт тоглоом наадгай, соёл урлаг, спортын төрлүүдийг залуучуудад өвлүүлэн хөгжүүлэх “Нэг санаа-Нэг зүрх” дорнын залуусын урлаг спортын бага наадмыг Сэргэлэн суманд амжилттай зохион байгуулан, уг наадамд 12 сумын 300 гаруй залуучууд, урлаг спортын төрлүүдээр өрсөлдлөө.

2.2.Боловсрол, соёлын хүрээнд 11 бүтээгдэхүүн тусган хэрэгжүүлсэн байна. 100 хувь биелэгдсэн 9 бүтээгдэхүүн, 90 хувь биелэгдсэн 1 бүтээгдэхүүн, 70 хувь биелэгдсэн 1 бүтээгдэхүүн байна. Нийт нусгагдсан бүтээгдэхүүний биелэлт 96.36 хувь байна.

2010 онд улс, аймаг орон нутгийн болон БСШУ-ны сайдын хөрөнгө оруулалтаар Цагаан-Овоо сумын сургуулийн ус цэвэршүүлэх төхөөрөмжийн сэлбэгт 2.0 сая, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын сургуулийн уурын зуухны засварт 70.0 сая, Гурванзагал сумын сургуулийн дотуур байрны засварт 156.0 сая, Булган сумын сургуулийн спорт заалны барилгад 202.700.0, Хөлөнбуйр сумын сургуулийн хичээлийн байрны их засварт 40.0 сая, Хан-Уул цогцолбор бага сургуулийн засварт 70.0 сая төгрөгийг, Хэрлэн суманд 640 хүүхдийн сургуулийн барилгад 600.0 сая төгрөгийн, 6 дугаар цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж 15.0 сая, Матад сумын цэцэрлэгийн барилгад 100.0 сая төгрөгийн, Цагаан-Овоо сумын сургуулийн дотуур байранд хөрөнгө оруулалт хийснээс гадна УИХ-ын гишүүний хөрөнгө оруулалтаар 450.0 сая төгрөгийн компьютерээр хангасан бөгөөд тогтвортой амжиргаа төслийн хүрээнд зарим сумдын сургууль, цэцэрлэгийн гар тогтооны хэрэгслийг бүрэн хангасан байна. Мөн сумдын соёлын төвүүдэд 2010 онд улсын болон орон нутгийн төсвөөр нийт 177234283 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд эдгээр арга хэмжээний үр дүнд соёлын төвүүдийн хөгжмийн зэмсэг техник хэрэгслийн хангамж сайжирч, соёлын ажилтнуудын мэдлэг чадвар нэмэгдэж, иргэдэд үйлчлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлсэн.

Дорнод аймгийн Засаг даргын 2010 оны 94 дүгээр захирамжаар аймаг, орон нутгийн сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд хяналт тавих орон тооны бус хяналтын

зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, сургууль, цэцэрлэг, дотуур байрны үдийн цай, хоолны цэсэнд хяналт тавин ажиллаа. Мөн хувилбарт сургалтаар 2010 онд 14 суманд 18 гэр цэцэрлэг ажиллаж, өнгөрсөн оныхоос 5-аар нэмэгдсэн бөгөөд сургуулиас өмнөх боловсролд хамрагдалс 0.1%-иар өссөн байна.

2.3.Эрүүл мэнд, спортын хүрээнд 7 бүтээгдэхүүн тусгагдсанаас 100 хувийн биелэлттэй 6, 70 хувийн биелэлттэй 1 бүтээгдэхүүн байна. Биелэлтийн дүн 95.71 хувьтай байна.

Хөлөнбуйр, Цагаан-овоо , Сэргэлэн сумын эмнэлэгт тус бүр 18.3 сая төгрөгний өртөг бүхий УАЗ 469 автомашинаар, 120 сая төгрөгний үнэ бүхий зайлшгүй шаардлагатай оношлогоо, эмчилгээний болон мэдээ, мэдээллийн тоног төхөөрөмж болох компьютер – 18ш, канон принтер – 6ш, Зүрхний цахилгаан бичлэг – 3ш, ЭХО – 3ш, лабораторын оношлуур – 3ш, массажны аппарат – 3, гүйлтийн зам – 3ш тус тус олгосон бөгөөд зарим өрхийн эмнэлгийг G mobile-ийн интернэтийн модемоор хангаад байгаа бөгөөд Хэрлэн сумын 7 дугаар багт өрхийн эмнэлэг шинээр барьж ашиглалтад оруулаад байна.

Хөтөлбөрт тусгагдсанаар өсвөр үе, залуучуудад зориулан БЗДХ, ХДХВ/ДОХ-ын халдвараас урьдчилан сэргийлэх, эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх сургалтын цогц үйлчилгээ үзүүлэх төв байгуулах хүрээнд 10 сая төгрөгийн санхүүжилтээгээр ЭМГ-т “Ирээдүйн босго” өсвөр үеийн хүүхдүүдэд зориулсан төв байгуулж, 1724 оюутан, сурагчдад тусламж, үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ үндэсний спортын IV наадмыг аймгийн хэмжээнд амжилттай зохион байгуулсан бөгөөд тэмцээнд нийт 10 сумын давхардсан тоогоор 190 тамирчид оролцов.

3.1.Эдийн засаг, бизнесийн орчин, төсөв санхүүгийн хүрээнд нийт 9 бүтээгдэхүүн тусгагдсанаас 98,88 хувийн биелэлттэй байна. 100 хувийн биелэлттэй 8 бүтээгдэхүүн, 90 хувийн биелэлттэй 1 бүтээгдэхүүн байна.

2010 онд улсын төсөвт 1,118.9 сая төгрөг орон нутгийн төсөвт 3744.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн улсын төсвийн орлогын төлөвлөгөөг 106.7 хувиар, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 104.7 хувиар тус тус давуулан биелүүлэхийн зэрэгцээ орон нутгийн төсвийн тэнцэл 2010 онд төлөвлөсөн хэмжээнээс 2.5 хувиар буюу 108.6 сая төгрөгөөр сайжирснаар төсвийн тэнцлийг төлөвлөсөн хэмжээнээс 0.2 хувиар сайжруулах талаар аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилтыг 12.5 дахин давуулан биелүүллээ. Аймгийн Засаг даргын 2009 оны 184 тоот захирамжаар аймаг сумын түр товчоо сумын комисс байгуулж 2010 оны 11 дүгээр сарын 11-17 ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж дуусаад байна.

2010 онд аймгийн төсвийн харилцах дансны үлдэгдлээс 216.3 сая төгрөг, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 140.9 сая төгрөг, улсын төсвийн Дорнод аймгийн

хөрөнгө оруулалт 269 сая төгрөг, мөн бүс нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр УТ-ийн хөрөнгө оруулалтаар 2800 сая төгрөг, ЭМЯ, ХХААХҮЯ, ЗГХЭГ, БОАЖЯ, БСШУЯ-ны сайдын багцаас 879.9 сая төгрөгийн ХАА-г зохион байгуулах эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлж нийт 4306.1 сая төгрөгийн 59 нэр төрлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ оны эхэнд батлагдсан.

Аймгийн ИТХ-ын 2010 оны 08 дугаар сарын 25-ний өдрийн хуралдаанаар орон нутгийн төсөвт тодотгол хийж 39.5 сая төгрөгийн 5 нэр төрлийн төсөл, арга хэмжээ нэмж баталсан байна. Мөн тодотголоор улсын төсвийн Дорнод аймаг дахь хөрөнгө оруулалт 269 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн төсөвт шилжүүллээ.

3.2.Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн хүрээнд 25 бүтээгдэхүүн тусгаж, 87.6 хувийн биелэлттэй байна. 100 хувийн биелэлттэй 18, 90 хувьтай 2, 70 хувьтай 1, 50 хувийн биелэлттэй 2, 30 хувийн биелэлттэй 1, 10 хувийн биелэлттэй 1 бүтээгдэхүүн тус тус байна.

Энэхүү салбарын хүрээнд Хэрлэн сумын захын гэр хорооллыг цахилгаанаар хангах ЦДАШ-ийг өргөтгөж, Чойбалсан хотын орон сууцны байруудын цэвэр усны хангамжийг сайжруулан, Үйлдвэр, үйлчилгээний барилга байгууламж, нийтийн болон амины орон сууц барих санал санаачлагыг дэмжин ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсаны 2010 онд Улсын төсвийн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Халхгол сумын Ялалт багаас Загасчдын хотхон, Буйрын застав хүртэл 29 км, 15 кВ-ын ЦДАШ, дэд станц барьж,

Аймгийн “Хөгжлийн цогц бодлого” болон Дорнод аймаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2007 оны 69 дүгээр тогтоолын дагуу Чойбалсан-Хайлаарын чиглэлийн агаарын нислэг 3 дугаар сарын 3-наас эхэлсэн бөгөөд үүнтэй холбогдуулан 1.85 км хатуу хучилттай замыг улсын төсвийн 350.0 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн нисэх онгоцны буудлын чигт барьж ашиглалтад оруулсан. аймгийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх хүрээнд “Хөрш зэргэлдээ 3 улсын аялал жуулчлалын өдөр” арга хэмжээг анх удаа 6 дугаар сарын 18-19-ны өдрүүдэд Дорнод аймагт зохион байгуулсан.

3.3.Хүнс,хөдөө аж ахуй, байгаль орчны хүрээнд 19 бүтээгдэхүүн тусгагдсанаас 92.1 хувь биелэгдсэн байна. 100 хувийн биелэлттэй 14 бүтээгдэхүүн, 90 хувийн биелэлттэй 2 бүтээгдэхүүн, 70 хувийн биелэлттэй 2 бүтээгдэхүүн, 30 хувийн биелэлттэй 1 бүтээгдэхүүн байна.

Мал хөлөөр нь гадаадад экспортлох ажлыг зохион байгуулах талаар холбогдох дээд байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлсэний үндсэн дээр Хавирга-Ар хашаатын

боомтоор нийт 4036 толгой адууг амьдаар нь БНХАУ-руу экспортолсон бөгөөд мах, сүүний чиглэлийн цэвэр үүлдэрийн үхэрийн тоо, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор Лимузин, Талын улаан, Семминталь, Хар тарлан, үүлдэрийн үхрийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажлыг зохион байгуулж 52 үнээнд хээлтүүлэг хийгээд байна.

2010 онд 52.2 мянган тн байгалийн хадлан авч төлөлвөгөөг 104.4 хувьар биелүүлээд байна. Мөн аймгийн Засаг даргын “Мал хамгаалах сан”-аас нийт 75.0 сая төгрөгний өртөг бүхий 3 механикжсан хадлангийн салаа байгуулах эргэн төлөгдөх нөхцөл бүхий төсөл шалгаруулан хэрэгжүүлсэн бөгөөд 2010 онд аймгийн хэмжээнд 3640 га-д талбайд улаанбуудай тариалж 5074.4 тн ургац хураан авсан нь өнгөрсөн жилээс 724.4 тонн буюу 16.6 %-иар илүү байна. Мөн 10 га-д овьёос тарьж 15.0 тонн ургац, 50 га-д гурвалжин будаа таргалж 45.0 тн ургац хураан авлаа. Тариалсан талбайн хэмжээ өнгөрсөн оноос 1020 га-гаар нэмэгдүүлэн атаршсан талбайг эргэлтэнд орууллаа. Мөн улсын төсвийн 243.0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар 18 инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг 14 суманд шинээр гаргалаа.

“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-2” болон “Хүнсний баталгаат байдал”, “Сүү”, “Нэг суурин, нэг бүтээгдэхүүн” гэх мэт дэд хөтөлбөрүүдийг боловсруулан батлуулж, хүн амын хүнсний бүтээгдэхүүний зохистой хангалтыг сайжруулах зорилгоор дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэхүү хөтөлбөрүүдийн хүрээнд “Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл-2010” үзэсгэлэн худалдааг “Эрүүл хүнс, эрүүл мэнд” уриан дор зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд хүнс үйлдвэрлэгч, хүнсний ногоо тариалагч 44 аж ахуй нэгж, иргэд оролцож, 2000 орчим иргэдэд үйлчилжээ.

2010 онд хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар 348 аж ахуйн нэгж, иргэдийн 4.8 тэр бум төгрөгийн санхүүжилт хүссэн төсөл хүлээн авч дээрх төслүүдээс нийтдээ арилжааны 3 банкинд Төсөл шалгаруулах дэд комиссын 14 удаагийн хурлаар дэмжигдсэн 2.265.1 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 189 төслийг хүргүүлсэн ба үүнээс 111 төсөл 1.050.0 сая төгрөгийн санхүүжилт аван үйл ажиллагаагаа явуулж байна. Жижиг дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлийг 2010 онд 111 аж ахуйн нэгж, иргэдэд нийт 1.050.0 сая төгрөгийн санхүүжилт үзүүлсэнээр 234 ажлын байр хадгалагдан үлдэж 215 ажлын байр шинээр бий болж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бодит дэмжлэг болж байна.

4.Батлан хамгаалах, гамшгаас хамгаалах хүрээнд нийт 6 бүтээгдэхүүн тусгасан бөгөөд 91.6 хувийн биелэлттэй байна. 100 хувийн биелэлттэй 5, 50 хувийн биелэлттэй 1 бүтээгдэхүүн байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Шинэ барга баруун, зүүн хошууны Ой шугуйн галаас сэргийлэх газар, Оросын холбооны улсын Өвөр байгалийн хязгаарын Онц байдлыг удирдах газартай ой хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хамтын ажиллагааг өргөжүүлэн хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөг шинэчилэн баталж гарын үсэг зурхын зэрэгцээ сумдын мэргэжлийн ангийг эхний ээлжинд бие даан

гамшигтай тэмцэх ажиллагааг зохион байгуулах чадавхийг дээшлүүлэх тал дээр анхааран ажиллаа.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА

П.БАТӨЛЗИЙ

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГА

Ц.ЖАНЛАВ

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БОЛОН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН 2010 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТОВЬЁОГ**

№	Агуулга	Зорилт	Хэрэгжих шатандаа	Хэрэгжилтийн явц								тасарсан	Гүйцэтгэлийн хувь,
				Биелсэн 100.0 %	Хэрэгжих шатандаа						10.0% /0.01%-19%/		
					90.0% /80%-99%/	70.0% /60%-79.%/	50.0% /40%-59%/	30.0% /20%-39%/					
Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД		25	4	21	2	2						97,66	
1.	1.1 Төрийн бодлогын талаар	9	2	7	1	1						95,5	
2.	1.2 Гадаад харилцааны талаар	8	1	7	1							98,75	
3.	1.3 Хуулийн хэрэгжилтийг хангах талаар	8	1	7	1							98,75	
Хоёр. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД		32	7	25	5	2						96,40	
4.	2.1 Хүн амын бодлогын талаар	14	4	10	4							97,14	
5.	2.2 Боловсрол, соёлын талаар	11	2	9	1	1						96,36	
6.	2.3 Эрүүл мэнд, спортын талаар	7	1	6		1						95,71	
Гурав: ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЭЦ, ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ХҮРЭЭНД		53	13	40	5	3	2	2	1			92,86	
7.	3.1 Эдийн засаг, бизнесийн орчин, төсөв, санхүүгийн талаар	9	1	8	1							98,88	

8.	3.2 Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн талаар	25	7	18	2	1	2	1	1		87,60
9.	3.3 Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны талаар	19	5	14	2	2		1			92,10
Дөрөв. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ ТАЛААР		6	1	4			1				91,6
Нийт дүн:		116	26	90	12	7	4	2	1		94,63

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА

П.БАТӨЛЗИЙ

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГА

Ц.ЖАНЛАВ

